



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-18, Факс: 32-70-18
E-mail: stategreatassembly@parliament.mn
[Http://www.parliament.mn](http://www.parliament.mn)

2023.01.02 № 01

Г “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын
овоолгын талаар

Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийг байгуулах тухай баримт бичигт 1973 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Монгол-Зөвлөлтийн Засгийн газар хоорондын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурснаар 1976 оноос уурхайн барилга байгууламжийн ажлыг эхлүүлэн ажилласан байдаг.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь зэс, молибдены баяжмалын экспортоор дэлхийд тэргүүлэгч 10 үйлдвэрийн нэг бөгөөд жилд 569 мянган тонн зэсийн баяжмал, 4700 мянган тонн молибдены баяжмал үйлдвэрлэдэг. Монгол Улс нь дэлхийн топ 10 молибдены баяжмал үйлдвэрлэгч орны тоонд багтдаг. 2017-2021 онд Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр нь 30 орчим сая ам.долларын геологи, хайгуулын ажил хийж, үйлдвэрийнхээ насхилтыг 30-аад жилээр нэмэгдүүлж, цаашид 70 гаруй жил ажиллах боломжийг бүрдүүлсэн.

2021 онд 32.5 сая тонн хүдэр боловсруулж, түүхэн дээд амжилт тогтоож, улс, орон нутгийн төсөвт 1.2 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлсэн амжилттайгаар Монгол Улсын ТОП-100 аж ахуйн нэгжийг 19 дахь удаагаа тэргүүлсэн үндэсний томоохон бүтээн байгуулагч татвар төлөгч юм.

Улсын Их хурлын гишүүн би Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг ашиглахтай холбоотой дараах асуулгыг Танд тавьж байна. Үүнд:

1.“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т хоёр төрлийн овоолго байдаг. Эхнийх нь тодорхой нөхцөлд үр ашигтай буюу балансын бус хүдрийн дөрвөн овоолго, хоёр дахь нь исэлдсэн хүдрийн дөрвөн овоолго бий. Технологид тохирохгүй зэсийн хүдрийн овоолгыг хэдэн оноос эхэлж бий болгосон, одоогийн нөөц хэмжээ, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын балансад бүртгэлтэй зэс талаарх мэдээлэл;

2.“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын овоолгын хэмжээ, цэвэр нөөц, өнөөдрийн зах зээлийн үнэ, хэдэн овоолго ашиглаж байгаа болон ашиглагдахгүй байгаа, тэдгээрт хичнээн тонн цэвэр зэс агуулагдаж байгаа талаарх мэдээлэл;

3.“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын төрийн эзэмших хувь хэмжээг бууруулсан тухай мэдээлэл. Үүнд: “Эрдмин” ХХК-д Эрдэнэ УБҮ-ийн 51 хувь нь 25 хувь болсон, “Ачит Ихт” ХХК эзэмшиж байсан 34 хувь 0 болгож бууруулсан нь хэзээ хэний шийдвэрээр шийдсэн тухай мэдээлэл;

4.Өнгөрсөн 30 жилд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ энэхүү овоолгыг яагаад ашиглаагүй талаарх мэдээлэл;

5.Өнгөрсөн хугацаанд "Эрдмин" ХХК, "Ачит Их" ХХК-уудын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, борлуулалт, төлсөн татварын хэмжээ жил тус бүрээр;

6.Овоолгууд дээр катодын зэс ялгах хэдэн үйлдвэр ажиллаж байгаа болон ашиглах байгаа хэлбэрийн талаарх мэдээлэл;

7.Эдгээр үйлдвэрүүдэд овоолгыг ззэмшүүлж байгаа хууль эрхзүйн баримт бичгүүдийн нэгдсэн мэдээлэл/ Монгол Улсын хууль, Засгийн газрын тогтоол, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын зөвлөлийн шийдвэр, үйлдвэрийн захирлын хэлцэл гэх мэт/;

8.Овоолго ашиглуулсны төлбөрт "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ төлбөр авдаг болон худалддаг эсэх талаар. Хэрвээ төлбөр авдаггүй үнэгүй ашиглуулдаг бол яагаад?

9."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын технологид тохирохгүй хүдрийн овоолгыг эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний явц, үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл зэрэг болно.

Дээрх асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлж, Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэнэ ўу.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Б. БАТТӨМӨР

2023000004